

ХӨВСГӨЛ АЙМГИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН 2024 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

2024.11.18

Мөрөн

№	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин	Гүйцэтгэл-ийн хувь
<p align="center">ЗОРИЛГО.УЛСЫН БҮРТГЭЛИЙН НЭГДСЭН ТОГТОЛЦООГ БҮРДҮҮЛЖ, ИРГЭНИЙ, ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН, ЭД ХӨРӨНГИЙН ЭРХИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ЦАХИМЖУУЛЖ, ТЕХНИК, ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ, ПРОГРАММ ХАНГАМЖИЙГ САЙЖРУУЛАХ. /“Алсын хараа-2050” зорилт 5.3, “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-ийн 5.3, “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 4.1.1, Улсын бүртгэлийн байгууллагын 2021-2024 оны стратеги төлөвлөгөө/</p>							
<p align="center">Зорилт1. Инновацийг дэмжигч, итгэл хүлээсэн, ил тод, нээлттэй төрийн үйлчилгээний байгууллага байна.</p>							
1.1	Тоон гарын үсэг олголтыг нэмэгдүүлж, бусдаар гүйцэтгүүлэх ажлыг зохион байгуулах	-	Хүсэлт гаргасан иргэдэд олгосон тоон гарын үсгийн тоо	51488	73000	Цахим гарын үсгийн тухай хууль, улсын бүртгэлийн байгууллагаас Монгол улсын 16 насанд хүрсэн иргэнд тоон гарын үсгийн гэрчилгээ олгох, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох журмын хүрээнд аймгийн “Хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөгжлийн төв”-ийн 15 албан хаагч болон “ИРГЭДЭЭ СОНСЪЕ” өдөрлөгт 40 иргэнд, Хуульчдын “Про боно” өдөрлөгт 10 иргэнд, сумдын “ХААН БАНК”-наас үйлчилгээ авч байгаа 254 иргэнд цахим гарын үсгийн тухай хууль, холбогдох журмын талаар мэдээлэл өгч тоон гарын үсэг олгох ажлыг зохион байгуулан ажилласан байна. Аймгийн хэмжээнд насанд хүрсэн нийт 90464 иргэнд тоон гарын үсэг олгохоос 2023 оны тайлант хугацаанд 51488 иргэнд буюу 57 хувьтай байсан бол 2024 оны тайлант хугацаанд 20973 иргэнд нийт 72461 иргэнд тоон гарын үсэг олгож. Цахим гарын үсэг олголт 80,09 хувьтай явагдаж байна. Мөн Улсын бүртгэлийн киоск машинаас 3990 иргэн тоон гарын үсэг авсан бүртгэлтэй байна.	99,2%
1.2.	Улсын бүртгэлийн	-	Киоск машинаар үзүүлсэн үйлчилгээг	5	10	Улсын бүртгэлийн үйлчилгээг цахим /киоск/ машинаар үзүүлэх үйлчилгээ, Улсын бүртгэлийн	

	үйлчилгээг цахим машинаар /Киоск/ үзүүлэх үйлчилгээг сурталчлах, үйлчилгээ авах иргэдийн тоог нэмэгдүүлэх		сурталчилсан тоо			хууль тогтоомж, өдөр тутмын үйл ажиллагааг хэлтсийн фэйсбүүк болон пэйж хуудсаар тогтмол сурталчлан ажиллаж тайлант хугацаанд нийт 13 мэдээлэл, 1 контентыг бэлтгэн байршуулж 412 удаагийн давтамжтайгаар олон нийтэд түгээн ажиллаж байна.	100%
		-	Үйлчилгээ авсан иргэдийн тоо	7043	11000	Тус хэлтсийн улсын бүртгэлийн хэлтсийн байранд байрлах 24/7 цахим үйлчилгээний киоск машин болон төв Хаан банк, Рэнчинлхүмбэ суманд байрлах 3 киоск машинаас 9936 лавлагаа, 3990 иргэн тоон гарын үсэг нийт 13926 үйлчилгээ авсан бүртгэлтэй байна.	100%
1.3.	Улсын бүртгэлийн үйлчилгээнд өгөгдлийн шинжилгээ хийх	-	Бүртгэлийн үйлчилгээнд дүн шинжилгээ хийсэн тоо	0	1	<p>2024 оны хэлтсийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн “Газраас бусад үл хөдлөх эд хөрөнгийг анх удаа бүртгэх болон Газар өмчлөх эрхийн улсын бүртгэл”-ийг сонгон авч “Өгөгдлийн шинжилгээ” хийлээ.</p> <p>2024 оны тайлант хугацаанд тус хэлтэс нь Газар өмчлөх эрх болон газраас бусад үл хөдлөх эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн анхны бүртгэлийн үйлчилгээг иргэдэд хуулийн хугацаанд түргэн шуурхай үзүүлж газар өмчлөх эрхийн бүртгэл нийт 187, газраас бусад үл хөдлөх эд хөрөнгийн анхны бүртгэл 977-г бүртгэж нийт 1164 хувийн хэрэг шинээр үүсгэн архивт байрлуулсан байна.</p> <p>Өгөгдлийн шинжилгээг дээрх бүртгэлүүдийн сүүлийн 3 жилийн эцсийн байдлаар харьцуулж график гарган харьцуулалтын аргаар хийсэн болно. График үзүүлэлтээс харахад 2024 онд үл хөдлөх эд хөрөнгийн анхны бүртгэл нь өмнөх жилүүдээс өссөн үзүүлэлттэй байна. 2024 оныг 2022 онтой харьцуулахад 22,1 хувиар өссөн. 2024 оныг 2023 онтой харьцуулахад 28,2 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Анхны бүртгэлийн үйлчилгээ өссөн нь тухайн онд шинээр орон сууцнууд ашиглалтанд орсон болон “Шинэ хоршоо” хөдөлгөөнтэй холбоотой шинээр байгуулагдсан хоршооны гишүүний малчны зээлэнд барьцаа хөрөнгө шаардлагатай болсонтой холбоотойгоор иргэд үл хөрөнгө эд хөрөнгө улсын бүртгэлд бүртгүүлэх эрс нэмэгдэж байна.</p> <p>Газар өмчлөх эрхийн бүртгэлийг сүүлийн 3 жилийн эцсийн байдлаар харьцуулан өгөгдлийн</p>	100%

						шинжилгээ хийхэд 2022 оноос газар өмчлөх эрхийн бүртгэл буурсан үзүүлэлттэй харагдаж байна. 2024 оныг 2022 онтой харьцуулахад 61,4 хувиар буурсан, 2023 онтой харьцуулахад 50,9 хувиар буурсан үзүүлэлттэй байна. Газар өмчлөх эрхийн бүртгэл буурсан үзүүлэлт нь 2024 онд газар өмчлөх захирамж гарахгүй байгаатай холбоотой юм.	
1.4.	Улсын бүртгэлийн Хууль тогтоомжийг боловсронгуй болгох, байгууллагын хэмжээнд дагаж мөрдөх дүрэм, журам, зааврыг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн боловсруулах, сурталчлах	-	Боловсруулж, батлуулсан хууль тогтоомж, тогтоол, шийдвэрт санал өгсөн тоо	6	8	Тайлант хугацаанд Улсын бүртгэлийн ерөнхий газрын газар, хэлтсээс ирүүлсэн 8 удаагийн төсөлд санал хүргүүлсэн байна. Үүнд: УБЕГ-н БТДШГ-с 2024.05.20-ны 7/6804 албан бичгээр ирүүлсэн “Улсын бүртгэлийн байгууллагын 2024 оны эрсдэлийн менежментийн төлөвлөгөөнд тусгах” санал, 2024.10.03-ны 7/11715 албан бичгээр ирүүлсэн “Хууль зүй, дотоод хэргийн яамны дэргэдэх хүүхдийн төлөө дэд зөвлөлийн 2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөө”-ний хэрэгжилтийг хангах улсын бүртгэлийн ерөнхий газрын дэд төлөвлөгөө”-нд тус тус санал хүргүүлсэн. УБЕГ-н Тамгын газар, Эрх зүйн хэлтсээс 2024.07.05-ны 2-1/9079 албан бичгээр ирүүлсэн “Улсын бүртгэлийн ерөнхий газрын Жендэрийн дэд зөвлөлийн 2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний төсөл”-д тусгах санал, 829 дугаар дотоод албан бичгээр “Өргөдөл, гомдол, санал, мэдэгдлийг хүлээн авах, шийдвэрлэх, хяналт тавих, тайлан гаргах” зааврын төсөлтэй танилцаж, холбогдох саналыг хүргүүлсэн. УБЕГ-н ХЭУБГ-с 2024.01.23-ны 4/957 дугаар албан бичгээр ирүүлсэн ХЭУБ-ийн 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний 7.1-д “Газар, хэлтсийн албан хаагчдыг чадавхжуулах, дадлагажуулах сургалт”-д холбогдох санал, 2024.02.20-ны 4/2084 албан бичгээр ирүүлсэн “Улсын бүртгэлийн байгууллагад Азийн хөгжлийн банкны техникийн туслалцааны дэмжлэгтэй хэрэгжүүлэх төслийн хүрээнд Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн системийн шинэчлэлтийн ажилд тусгах” санал, 2024.03.01-ний 4/2695 албан бичгээр ирүүлсэн “Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн үйл ажиллагаанд хэрэглэх маягтын загварыг шинэчлэн боловсруулах төсөл”-д тус тус санал хүргүүлсэн. Мөн УБЕГ-ын Улсын бүртгэлийн нэгдсэн архиваас	100%

						2024.10.25-ны 9/13413 албан бичгээр ирүүлсэн "Байгууллагын архивын үйл ажиллагааны нийтлэг журам"-ын нэмэлт өөрчлөлтийн төсөлд тусгах саналаа хүргүүлж ажиллалаа.	
			Хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн сурталчилгааны тоо	6	8	Цахим гарын үсгийн тухай хууль, Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль, Аймаг, нийслэл, сум дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хууль, Улсын бүртгэлийн тухай хуулийн хэрэгжилттэй холбогдуулан өөрсдийн цахим мэдээллийг иргэдэд фэйсбүүк пэйж хуудас болон цахим хуудсаар дамжуулан сурталчилж 2024 оны тайлант хугацаанд нийт 71 мэдээлэл, 6 контентыг бэлтгэн байршуулж 1000 гаруй удаагийн давтамжтайгаар олон нийтэд түгээн ажилласан байна.	100%
1.5.	Улсын бүртгэлийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, улсын бүртгэлийн хууль тогтоомжийг сурталчлах, соён гэгээрүүлэх зорилгоор контент бэлтгэж, түгээх	800 мянган төгрөг	Сурталчилсан мэдээ мэдээлэл, сурталчилгаа, контентын тоо	4	10	Тус хэлтсээс санаачлан гаргасан шинэ, шинэлэг санаачлагаар "Бүртгэлхүү, Бүртгэлмаа" контентыг 2023 онд эхлүүлсэн бөгөөд тайлант хугацаанд "Иргэний шилжилт хөдөлгөөний бүртгэл", "Цахим гадаад паспорт", "24/7 цахим үйлчилгээ", "Тусгай хэрэгцээт иргэнд гэрт нь очиж улсын бүртгэл хөтлөх" "Тоон гарын үсэг", "Ногоон нэгж" сэдвээр 6 удаагийн контент бүтээж цахим хуудсанд байршуулаад байна. Энэхүү контент нь гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу цаашид үргэлжлэх бөгөөд "Авлигын эсрэг үйл ажиллагаа", "Үндэсний бичиг", "Хөгжлийн бэрхшээлтэй иргэн" зэрэг 4 сэдвийн хүрээнд шинэ контентыг бүтээхээр төлөвлөн тухай бүрт цахим хуудаснаа байршуулан бүртгэлийн үйл ажиллагааг сурталчлан ажиллах болно.	100%
Зорилт 2. Цахим бүртгэлийг хөгжүүлэх замаар улсын бүртгэлийн үйлчилгээний чанар, хүртээмж, шуурхай байдлыг нэмэгдүүлнэ.							
2.1.	"Улсын бүртгэлийн хэлтсийн зөөврийн тоног төхөөрөмжөөр болон 24/7 цэг"-ийн үзүүлж байгаа үйлчилгээний чанар,	Төрийн болон төрийн бус байгууллагын тусламж дэмжлэг	Улсын бүртгэлийн зөөврийн тоног төхөөрөмжөөр үзүүлсэн үйлчилгээний тоо	6	6	Улсын бүртгэлийн үйлчилгээг тэгш, хүртээмжтэйгээр хүргэх зорилгоор Арбулаг, Баянзүрх, Галт, Тариалан, Мөрөн, Эрдэнэбулган зэрэг 6 сумын улсын бүртгэгчид сумандаа амьдардаг өндөр настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, хүнд өвчтэй болон ерөнхий боловсролын сургуулийн сурагчдад зөөврийн 4G төхөөрөмж ашиглан 27 иргэнд тоон гарын үсэг олгох, биеийн давхцахгүй өгөгдлийн бүртгэл, иргэний шилжилт хөдөлгөөний бүртгэл, иргэний улсын бүртгэлийн	100%

	хүртээмжийг нэмэгдүүлэх					лавлагаа зэрэг үйлчилгээг үзүүлсэн.	
			24/7 цэгийг шинээр нэмэгдүүлэх	0	1	Улсын бүртгэлийн үйлчилгээг иргэдэд түргэн шуурхай, тасралтгүй хүргэх зорилгоор 24/7 цэгийг хэлтсийн үйлчилгээний заал, Хаан банк, Рэнчинлхүмбэ суманд 2024 оны 02 дугаар сарын 06-ны өдөр нээн ажиллуулж иргэдэд тогтмол үйлчилж байна. Мөн 24/7 үйлчилгээг өөрсдийн бүтээсэн Бүртгэлхүү, Бүртгэлмаа контентоор дамжуулан иргэдэд сурталчилсан бөгөөд иргэдийн сэтгэл ханамж өндөр байна.	100%
2.2.	Нотариатч мэдүүлэг гаргагчийн хүсэлтээр хуулийн шаардлага хангасан мэдүүлэг, холбогдох баримт бичгийг улсын бүртгэлийн мэдээллийн санд илгээх, бүртгүүлэх зуучлалын системийг боловсронгуй болгох	-	“Мэдээлэл нийлүүлэх, мэдээлэл авах гэрээ”-г шинэчлэн байгуулсан нотариатчидын тоо	0	4	Мэдээлэл нийлүүлэх, мэдээлэл авах гэрээ”-г шинэчлэн байгуулж, “Голомт банк” ХК-иас барьцаат зээлийн гэрээ бүртгүүлэх, барьцааны гэрээ дуусгавар болгох үйлчилгээний нотлох баримтыг нотариатчаас улсын бүртгэлийн үйлчилгээг зуучлах, мэдүүлэг гаргагчийн улсын бүртгэлийн байгууллагад гаргасан мэдүүлэг, холбогдох баримт бичгийг хуулийн шаардлага хангуулан мэдүүлэг гаргагчийн хүсэлтээр тус тус дундын мэдээллийн сангаар дамжуулан улсын бүртгэлийн мэдээллийн санд цахимаар илгээж эхэлсэн бөгөөд одоогийн байдлаар цахимаар бүртгэл хийх хүсэлт ирээгүй байна.	80%
		-	Нотариатчаар зуучлуулан бүртгэсэн бүртгэлийн тоо	0	5		
2.3.	Барьцааны гэрээний болон барьцааны гэрээ дуусгавар болгох бүртгэлийг цахимаар бүртгэх системийн хэрэглээ, цахим хэрэглэгчийн тоог нэмэгдүүлэх	-	Цахимаар бүртгүүлэхээр системд холбогдсон банк, санхүүгийн байгууллагын тоо	0	4	Монголын Ипотекийн корпарацн ОССК /МИК/ болон Голомт банк цахимаар бүртгүүлэх системд холбогдсон.	100%
		-	Цахимаар бүртгэсэн барьцааны гэрээний бүртгэлийн тоо	0	10	Хөвсгөл аймгийн хэмжээнд цахимаар бүртгүүлэх барьцааны гэрээний бүртгэл бүртгэгдээгүй.	100%
		-	Цахимаар бүртгэсэн барьцааны гэрээ дуусгавар болгох бүртгэлийн тоо	0	10	Монголын Ипотекийн корпарацн ОССК /МИК/-аас цахимаар илгээсэн барьцааны гэрээ дуусгавар болгох бүртгэлийн 32 мэдүүлэг хүлээн авч 2 мэдүүлгийг татгалзаж, 30 барьцааны гэрээ дуусгавар болгох бүртгэлийг бүртгэсэн байна.	100%

						Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн газраас ирүүлсэн 2024 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн 5/13341 дугаартай “Чиглэл хүргүүлэх тухай” албан бичгийн дагуу 10 дугаар сарын 28-ны өдрөөс эхлэн “Голомт банк”ХК-иас барьцаат зээлийн гэрээ бүртгүүлэх, барьцааны гэрээ дуусгавар болгох үйлчилгээний нотлох баримтыг нотариатчаас улсын бүртгэлийн үйлчилгээг зуучлах, мэдүүлэг гаргагчийн улсын бүртгэлийн байгууллагад гаргасан мэдүүлэг, холбогдох баримт бичгийг хуулийн шаардлага хангуулан мэдүүлэг гаргагчийн хүсэлтээр тус тус дундын мэдээллийн сангаар дамжуулан улсын бүртгэлийн мэдээллийн санд цахимаар илгээж эхэлсэн байна.	
2.4.	Иргэний баримтын архивын тодорхойгүй төлөвт байгаа эх нотлох баримтыг цахимжуулах	Улсын төсөв	Иргэний баримтын архивын тодорхойгүй төлөвт байгаа эх нотлох баримтыг цахимжуулсан хувийн хэргийн тоо	0	300	Иргэний баримтын архивт хадгалагдаж байгаа тодорхойгүй төлөвтэй 1100 иргэний хувийн хэргийг мэдээллийн санд шалгаж нийслэл болон бусад аймгийн хаягтай 637 иргэний ХААТР-11 маягт болон хувийн хэргийг харьяа аймаг нийслэлийн улсын бүртгэлийн хэлтэст албан бичгээр хүргүүлсэн ба Хөвсгөл аймгийн хаягтай 463 иргэний хувийн хэргийг иргэний баримтын архивт баяжилт хийж цахимжуулсан байна.	100%
2.5.	Иргэний улсын бүртгэл, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн үйлчилгээг хууль тогтоомж, холбогдох журмын дагуу хөтлөх	-	Иргэний улсын бүртгэлийн тоо	32000	33000	Тайлант хугацаанд Иргэний улсын бүртгэлийн чиглэлээр 47054 бүртгэл хөтөлсөн байна.	100%
			Хуулийн этгээдийн улсын бүртгэл хөтөлсөн тоо	700	750	Тайлант хугацаанд Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн чиглэлээр 1066 материал хүлээн авч бүртгэл хөтөлсөн байна.	100%
			Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл хөтөлсөн тоо	10500	11000	Тайлант хугацаанд Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн нийт 13416 мэдүүлэг хүлээн авч, холбогдох бүртгэлийг хөтлөн ажилласан.	100%
2.6.	Архивын үйл ажиллагааны төлөвлөгөө гаргаж, хэрэгжилтийг хангах	-	Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	100	100	2024 оны архивын үйл ажиллагааны төлөвлөгөөг 8 арга хэмжээтэйгээр боловсруулан 2024 оны 01 дүгээр сарын 31-ний өдөр хэлтсийн даргаар батлуулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Төлөвлөгөөний дагуу 8 арга хэмжээ 100 хувь хэрэгжсэн.	100%

2.7	Иргэний улсын бүртгэлийн цахим мэдээллийн санд хил нэвтрэх үнэмлэхийн бүртгэлийг хөтлөх.	-	Хил нэвтрэх үнэмлэхийн бүртгэл хөтөлсөн тоо	0	500	Хил орчмын нутаг дэвсгэрт хялбаршуулсан журмаар зорчих үнэмлэх буюу ОХУ-н хавсралтыг Иргэний улсын бүртгэлийн цахим мэдээллийн сангаас олгож 682 үнэмлэхийн бүртгэл хөтөлсөн.	100%
2.8	Байгууллагаас сар бүр үзүүлсэн үйлчилгээний талаар инфографик мэдээлэл бэлтгэх, олон нийтэд хүргэх	-	Сар бүр иргэн, хуулийн этгээдэд үзүүлсэн үйлчилгээний талаарх инфографик мэдээллийг бэлтгэн брошур хэлбэрээр байгууллагын цахим хуудас болон мэдээллийн самбарт байршуулсан тоо;	12	12	Тус хэлтсийн 1-10 дугаар сарын иргэн, хуулийн этгээдэд үзүүлсэн үйлчилгээний талаар 10 удаагийн инфографик мэдээллийг үнэн зөв гарган тус, хэлтсийн цахим хуудас болон хэлтсийн ил тод байдлын самбар, олон нийтийн сүлжээнд байршуулан, хэлтсийн цахим хуудсанд 10 мэдээллийг оруулан, 274 удаагийн давтамжтай түгээн ажиллаж байна.	100%
2.9	Иргэн, хуулийн этгээдээс ирүүлсэн өргөдөл, гомдлыг шуурхай хянан шийдвэрлэх, түүнд хяналт тавих ажлыг сайжруулах.	-	Иргэн, хуулийн этгээдээс ирүүлсэн өргөдөл, гомдлыг шийдвэрлэсэн хувь	100	100	Тайлант хугацаанд хэлтсийн хэмжээнд иргэдээс 128 өргөдөл, гомдол хүлээн авч 100% шийдвэрлэсэн бөгөөд 1,2,3 дугаар улирлын өргөдөл гомдлын мэдээг УБЕГ-т хугацаа хоцроолгүй үнэн зөв хүргүүлэн ажиллаж байна.	100%
2.10	Гадаад паспортын бүртгэлийн үйлчилгээг анхан шатны нэгжид үзүүлэх	15 сая төгрөг	Гадаад паспортын бүртгэлийн үйлчилгээг үзүүлж буй сумын тоо	0	7	Тус хэлтэс нь Үндэсний энгийн гадаад паспортын бүртгэлийг анхан шатны нэгжээс үзүүлэх ажлын хүрээнд аймгийн төвөөс хол, алслагдсан Мөрөн, Тариалан, Рэнчинлхүмбэ, Цагаан-Уул, Цэцэрлэг, Их-Уул, Цагаан-Үүр, Чандмань-Өндөр, Эрдэнэбулган сумдад нэвтрүүлэхээр нийт 42.140.000 төгрөгийн төсвийг сумын ИТХ-р шийдвэрлүүлэн Улсын бүртгэлийн хэлтэст үндэсний энгийн гадаад паспортыг бүртгэл хөтөлх дадлага хийлгэн гадаад паспортын бүртгэлийг тухайн сумын улсын бүртгэгч нар сумандаа хөтлөн ажиллаж байна. Ингэснээр нийт 9 суманд гадаад паспортын бүртгэл хөтөлх боломж бүрдсэн. 2024 оны тайлант хугацаанд Цэцэрлэг суманд	100%

						102, Цагаан-Уул суманд 85, Их-Уул суманд 102, Тариалан суманд 165, Эрдэнэбулган суманд 21 нийт 475 иргэний гадаад паспортын бүртгэл хөтөлсөн байна.	
2.11	Алслагдсан сум багт хүрч үйлчлэх зорилгоор туулах чадвар сайтай машин шийдвэрлүүлэх	200 сая төгрөг	Шийдвэрлүүлсэн машины тоо	0	1	Туулах чадвар сайтай автомашиныг шийдвэрлүүлэх хүсэлтээ Хүүхэд, гэр бүл, халамж, нийгмийн хамгааллын сайд Л.Энх-Амгалан, Улсын их хурлын гишүүн Л.Мөнхбаатар, Ц.Даваасүрэн, аймгийн Засаг дарга Л.Төмөрбаатар нарт албан бичиг хүргүүлэн хүсэлтээ уламжлан шийдвэрлүүлэхээр ажиллаж байна.	50%
2.12	Улсын бүртгэлийн үйлчилгээний зааланд ашиглагдах дугаар дуудах машиныг шийдвэрлэх	3 сая төгрөг	Шийдвэрлүүлсэн дугаар дуудах машины тоо	0	1	Хэлтсийн үйлчилгээний зааланд дугаар дуудах машин ашиглаж эхэлсэн бөгөөд, иргэдэд үйлчилгээ үзүүлдэг 8 цонхонд дугаар дуудагч машиныг өдөр тутамдаа ажиллуулж хэвшсэн. Дугаар дуудагч машины төсөв болох 4.000.000.0 /дөрвөн сая/ төгрөгийг хэлтсийн урсгал санхүүжилтээр шийдвэрлэсэн.	100%
Зорилт 3. Улсын бүртгэлийн мэдээллийн аюулгүй байдал, нэгдсэн сангийн нууцлалыг ханган, эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлнэ.							
3.1.	Эцсийн өмчлөгчийн мэдээллийн үнэн зөв, найдвартай байдлыг хангах зорилгоор хяналт шалгалтыг эрчимжүүлэх, зөрчил илэрсэн тохиолдолд хариуцлагын арга хэмжээ авах	-	Илрүүлсэн зөрчлийн тоо	0	5	2024 онд эцсийн өмчлөгч нөхөн бүртгүүлсэн бүртгэл байхгүй бөгөөд шинээр байгуулагдсан 614 хуулийн этгээдийн эцсийн өмчлөгчийг үнэн зөв бүртгэсэн эсэхэд хяналт тавьж ажиллалаа. Хяналт шалгалтаар зөрчил дутагдал илрээгүй болно.	100%
			Зөрчил арилгасан тоо	0	5		
3.2.	Улсын бүртгэлийн хууль тогтоомжийн биелэлтэд хяналт тавих замаар улсын бүртгэлийн үнэн	-	Хяналт шалгалтын төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь.	100	100	2024 оны хяналт шалгалтын ажлын төлөвлөгөөний дагуу Улсын бүртгэл, түүнтэй холбоотой бусад үйл ажиллагаанд зөрчил гарахаас урьдчилан сэргийлэх, зөрчлийг илрүүлэх, таслан зогсоох, илэрсэн зөрчлийг арилгуулах, улсын бүртгэлийн ажилтны үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, улсын бүртгэлийн хууль тогтоомжийн биелэлтэнд хяналт тавих чиг	

	зөв байх зарчмыг хангах				<p>үүргийн дагуу 5102 бүртгэлд хяналт тавьж ажиллалаа. Үүнээс: Иргэний улсын бүртгэлийн чиглэлээр-2530, Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн чиглэлээр-1068, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн чиглэлээр-228, Улсын бүртгэлийн архивын чиглэлээр-1276 тус тус шалгаж ажиллалаа.</p> <p>Тайлант хугацаанд иргэдээс нийт 81 өргөдөл, санал, гомдлын мөрөөр хийсэн шалгалтаар: Иргэний улсын бүртгэлийн чиглэлээр-30, Эд хөрөнгийн улсын бүртгэлийн чиглэлээр-44, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн чиглэлээр-7, Улсын бүртгэлийн архивын чиглэлээр-0 тус тус зөрчил илэрсэн байна.</p> <p>Хяналтын улсын байцаагчийн 81 дүгнэлт гарсан бөгөөд үүнээс Иргэний улсын бүртгэлийн чиглэлээр-30, Хуулийн этгээдийн чиглэлээр-7, Эд хөрөнгийн улсын бүртгэлийн чиглэлээр-44 дүгнэлт гарган ажилласан байна.</p>	100%
		Дотоод хяналт шалгалтын ажлын хэсгийн шалгалтын тоо	2	4	<p>Хэлтсийн албан хаагчдыг аливаа эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор 2022 онд Дотоод хяналт шалгалтын ажлын хэсэг байгуулан ажиллаж байгаа бөгөөд уг ажлын хэсэг 2024 оны төлөвлөгөөг 11 арга хэмжээтэйгээр төлөвлөн хэлтсийн даргаар батлуулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Төлөвлөгөөний дагуу 4 удаагийн хяналт шалгалтыг хэлтсийн бичиг хэргийн эрхлэгч, мэдээлэл технологийн ажилтан, иргэний улсын бүртгэлийн сумын улсын бүртгэгч, хэлтсийн нийт улсын бүртгэгч нарын албан тушаалын тодорхойлолтод заасан ажил үүргийн хүрээнд зохион байгуулж, хяналт шалгалтын үр дүнг илтгэх хуудсаар хэлтсийн даргад танилцуулан ажилласан.</p>	100%

3.3.	Архивын эх нотлох баримт цахимжуулах, лавлагаа олгох үйл ажиллагаанд хяналт тавих	-	Хяналт шалгалтын төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь.	0	100	Архивын эх нотлох баримт цахимжуулах, лавлагаа олгох үйл ажиллагаанд хяналт тавих ажлын хүрээнд нийт 5102 архивын эх нотлох баримтыг Иргэний улсын бүртгэлийг цахимжуулсан материалыг харах, ашиглах, засварлах программ хангамжаас бүрэн цахимжсан эсэх, Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийг EPRS-2 программаас мета дата буюу бүртгэлийн төрлөөр цахимжсан эсэх, Хуулийн этгээдийн эрхийн улсын бүртгэлийг ERS программаас үйлчилгээний нэршил зөв орсон эсэхийг тус тус нотлох баримттай тулган шалгаж төлөвлөгөөний хэрэгжилт 100% хэрэгжсэн.	100%
3.4.	Байгууллагын санхүүгийн үйл ажиллагааг мэргэжлийн удирдлагаар хангах, төсвийн хөрөнгийг зүй зохистой зарцуулах, тайлагнах, байршуулах, санхүүгийн дотоод аудитыг хэрэгжүүлэх	1.5 тэрбум	Шилэн дансны хуулийн хэрэгжилтийн хувь.	100	100	2014.07.01-ний өдөр батлагдсан “Шилэн дансны тухай” хууль хэрэгжиж эхэлснээс хойш тус хэлтэс нь хуулийн хэрэгжилтийг 100 хувь ханган ажиллаж байна.	100%
			Тайлагнаж, хугацаандаа байршуулсан мэдээллийн тоо.	159	159	Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг ханган тайлант хугацаанд 139 мэдээллийг info.shilendans.gov.mn сайтад байршуулан ажиллаж байна. Хуулийн хугацаа болоогүй 32 мэдээлэл байгаа болно.	100%
			Тайлагнасан мэдээллийн мөнгөн дүн	1 584 448 700 төгрөг	1 402 185 500 төгрөг	Тус хэлтэст 2024 онд 1.609.555.300 төгрөгийн урсгал санхүүжилт батлагдсанаас тайлант хугацаанд 1.470.896.100 төгрөгийн санхүүжилтээр үйл ажиллагааг явуулж, үндсэн үйл ажиллагааны орлогоос 243 395 223 төгрөгийг оруулж улсын төсөвт төвлөрүүлээд байна. Улсын төсөвт төвлөрүүлсэн орлогын задаргаа: ➤ Иргэний гэр бүлийн 8н төрлийн үйлчилгээ 6 285 000 ➤ Шилжилт хөдөлгөөний бүртгэл 3 623 000 ➤ Иргэний цахим үнэмлэх 75 550 000	100%

						<ul style="list-style-type: none"> ➤ Хил зорчих үнэмлэх 2 046 000 ➤ Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл 132 316 223 ➤ Хуулийн этгээдийн улсын бүртгэл 23 575 000 	
3.5.	Аймгийн аудитын газар болон бусад байгууллагаас ирүүлсэн зөвлөмжид хяналт тавих, мэдээ мэдээлэл, тайланг хугацаанд нь хүргүүлэх	-	Зөвлөмж, акт, албан шаардлагын тоо, биелэлтийн хувь.	100	100	2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар Аймгийн Төрийн аудитын газраар аудит хийлгэн түүвэр шалгалтанд хамрагдан санхүүгийн ямар нэгэн зөрчил төлбөргүй, удирдлагад илгээх захидал авч ажилласан.	100%
3.6.	Цахим мэдээллийн сан, мэдээллийн нэгдсэн сүлжээний хэвийн үйл ажиллагаа, аюулгүй байдлыг ханган ажиллах	-	Мэдээллийн нэгдсэн сүлжээний аюулгүй байдал, тоног төхөөрөмжийн хэвийн ажиллагааг ханган ажилласан тоо	9	9	Хэлтсийн мэдээлэл технологийн ажилтны 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу I, III дугаар улиралд Хэлтсийн албан хаагчдын “Улсын бүртгэлийн цахим мэдээллийн нэгдсэн санд мэдээлэл хүлээн авах, хадгалах, түүний аюулгүй байдлыг хангах журам”-ын хэрэгжилтийг хэрхэн хангаж ажиллаж байгаад хяналт тавих, цаашид өдөр тутмын бүртгэлийн үйл ажиллагаанд журмын хэрэгжилтийг хангуулан ажиллах шалгалтын удирдамжийг боловсруулан шалгалтаар илэрсэн зөрчлийг хэлтсийн албан хаагч тус бүрээр арилгуулан цахим мэдээллийн сан, мэдээллийн нэгдсэн сүлжээний хэвийн үйл ажиллагаа, аюулгүй байдлыг ханган ажилласан. Мөн хэлтсийн албан хаагчдаас ирүүлсэн 56 удаагийн засвар үйлчилгээ, програм, бүртгэлийн сүлжээнтэй холбоотой дуудлага хүлээн авч, тоног төхөөрөмжийн хэвийн үйл ажиллагааг хангасан. Мөн МУИХурал болон АНСДИТХурлын сонгуулийн сонгогчийн ирц бүртгэлийн программ онлайн сүлжээнд ажилласантай холбогдуулан туршилтын сонгууль, сонгуулийн өдрийн сүлжээний асуудлыг 100% хариуцан ажилласан.	100%
3.7.	Хэлтсийн төрийн үйлчилгээний	-	Төлөвлөгөөнд тусгагдсан тоног	0	5	Тус хэлтсийн ерөнхий нягтлан бодогч 2024 оны 04 дүгээр сарын 17-19-ны өдрийн хооронд	

	албан хаагчдын албан хэрэгцээнд ашиглагдаж байгаа тоног төхөөрөмжийг иж бүрнээр шинэчлэх		төхөөрөмжийг шинэчилсэн тоо			Улаанбаатар хотод “Хууль зүй дотоод хэргийн яамны нягтлан бодох бүртгэл, санхүүгийн програм”-ын сургалтад суух үед Улсын бүртгэлийн ерөнхий газраас зөөврийн компьютерыг шинэчлэн өгсөн. Мөн хэлстийн урсгал санхүүжилтээс 600000 төгрөгийг шийдвэрлүүлэн төрийн үйлчилгээний албан хаагчдын зөөврийн компьютерт ssd hard disk нэмэлтээр тавьж, үзүүлэлтийг сайжруулсан.	100%
Зорилт 4. Хуулиар олгосон тусгай чиг үүргийг хэрэгжүүлнэ.							
4.1.	МУИХ-ын 2024 оны ээлжит сонгуулиар улсын бүртгэлийн байгууллагын хэрэгжүүлэхээр заасан чиг үүргийг ханган ажиллах.	-	Улсын бүртгэлийн байгууллагын хэрэгжүүлэх төлөвлөгөөний биелэлтийн хувь	100	100	Монгол Улсын Их хурлын сонгуулийн тухай хуульд заасны дагуу Хөвсгөл аймгийн 23 сумын сонгуулийн хэсэг байгуулах тухай сумдын ИТХ тогтоолыг хуулийн хугацаанд нь хүлээн авч цахимжуулан, улсын бүртгэлийн мэдээллийн санд хэсгийн төв санал авах байрыг шивж оруулан тогтоолын эх хувийг Иргэний улсын бүртгэлийн газарт хүргүүлсэн байна. Улсын бүртгэлийн байгууллагын 129 хэсгийн хороонд ажиллах 132 итгэмжлэгдсэн ажилтанд ирц бүртгэлийн программын болон эрх зүйн сургалтыг 2024 оны 06 дугаар сарын 19-нд зохион байгуулсан. 2024 оны 06 дугаар сарын 28-ны өдөр Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2024 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн А/109 дугаар тушаалын дагуу “Удирдлагын шуурхай баг”-ийн хуваарь /06.00-23.00 цаг/ гарган дараах ажлыг зохион байгуулж ажиллалаа: Үүнд: Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль, түүнтэй холбоотой хууль тогтоомжийг нэг мөр ойлгон хэрэгжүүлж санал авах өдөр сонгогчдын нэрийн жагсаалттай холбоотой гарсан асуудал, мэдээллийг шуурхай багийн хуваарийн дагуу хариуцсан албан хаагчтай холбогдож итгэмжлэгдсэн ажилтан хууль тогтоомжийн хүрээнд шуурхай шийдвэрлэж, чиглэл, зөвлөмж өгч арга зүйгээр ханган Мэдээлэл технологийн газраас өгсөн гарын авлага, анхааруулга, санамжийг 132 итгэмжлэгдсэн ажилтанд сумдын улсын бүртгэгч нар хэвлэн өгч, танилцсан эсэхийг шуурхай багийн гишүүд утсаар нэг бүрчлэн холбогдон асууж дахин нэмэлт мэдээлэл өгч	100%

						<p>ажиллалаа.</p> <p>Сонгуулийн хэсгийн хорооны сервер, клиент компьютерийн сүлжээний холболт, пинг шалгах, модем сүлжээ хэвийн эсэх, бусад дагалдах тоног төхөөрөмжийн бүрэн бүтэн байдлыг шалган, сонгуулийн үйл ажиллагаа хуульд заасан хугацаанд амжилттай эхэлсэн. Сонгогчийн ирцийн мэдээг тухай бүр мэдээг илгээх, илгээгээгүй сонгогчийн мэдээг байнга тулган шалгаж тогтмол итгэмжлэгдсэн ажилтантай холбоо барьж Монгол Улсын Их хурлын сонгуулийг амжилттай зохион байгуулсан байна.</p>	
4.2.	<p>Аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-ын ээлжит сонгуулиар улсын бүртгэлийн байгууллагын хэрэгжүүлэхээр заасан чиг үүргийг ханган ажиллах</p>	-	<p>Улсын бүртгэлийн байгууллагын хэрэгжүүлэх төлөвлөгөөний биелэлтийн хувь</p>	100	100	<p>АНСДИТХ-н сонгуулиар ажиллах итгэмжлэгдсэн ажилтан нарт программын болон эрх зүйн улсын бүртгэлийн сургалтыг 2024 оны 09 дүгээр сарын 29-нд зохион байгууллаа.</p> <p>2024 оны 10 дугаар сарын 1-11-ний өдөр хүртэл хэлтсийн даргаар батлуулсан “Шуурхай баг”-ийн хуваарь гарган дараах ажлыг зохион байгуулж ажиллалаа.</p> <p>Сонгуулийн өдөр хийх ажлын гарын авлага, анхааруулга, санамжийг 131 итгэмжлэгдсэн ажилтанд болон сумдын улсын бүртгэгч нар хэвлэн өгч тарааж танилцсан эсэхийг шуурхай багийн гишүүд утсаар нэг бүрчлэн холбогдож асууж дахин нэмэлт мэдээлэл өгч, сонгуулийн хэсгийн хорооны сервер, клиент компьютерийн сүлжээний холболт, пинг шалгах, модем, старлинг сүлжээ хэвийн эсэх, бусад дагалдах тоног төхөөрөмжийн бүрэн бүтэн байдал, моторын аюулгүй хэвийн ажиллагааг хангаж хамтарч ажиллах тухай тус аймгийн сонгуулийн хороонд болон сумын хэсгийн хороонд албан тоот хүргүүлэн ажиллалаа.</p> <p>Сонгуулийн хэсгийн хорооны старлинг болон бусад тоног төхөөрөмж, итгэмжлэгдсэн ажилтаны ирц бэлэн байдлыг өглөөний 05 цагаас эхлэн утасдан шалгаж 07:00 минутад 129 хэсгийн хороо амжилттай нээлтийн тайланг хэвлэж эхлэн зөөврийн хайрцагаар санал авсан иргэдийн мэдээллийг бүрэн уншуулж ирц бүртгэлийн явц хэвийн үргэлжилсээр 20:00 минутад хаалтын</p>	100%

						тайланг хэсэг тус бүрээр авч УБЕГ-ын хяналтын программын тоотой тулган шалгахад зөрчил илэрсэнгүй тоон мэдээ таарлаа. Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1, 24.2, 24.3 дахь хэсэгт заасны дагуу Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын А/170 дугаартай "Иргэний шилжилт хөдөлгөөний бүртгэлийг сэргээх тухай" тушаалын дагуу бүртгэлийг сэргээж иргэний баримтын архивт хадгалагдаж байсан иргэний шилжилт хөдөлгөөний бүртгэлийн дэвтэр, үнэт цаас /ИУБ-22/-ыг тухайн сумын улсын бүртгэгч нарт хүлээлгэн өгч ажилласан байна.	
Зорилт 5.Төсөл, хөтөлбөр хэрэгжүүлнэ.							
5.1.	Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл болон хуулийн этгээдийн улсын бүртгэлийн үйлчилгээг анхан шатны нэгжид шилжүүлэх.	ADB төсөл	Эд хөрөнгийн болон хуулийн этгээдийн бүртгэлийн үйлчилгээг үзүүлэх боломж бүрдсэн сумдын тоо	2	11	Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн үйлчилгээг сумынхаа иргэдэд хүргэх ажлыг Баянзүрх, Галт, Их-Уул, Тариалан, Хатгал, Улаан-Уул, Цагаан-Үүр, Чандмань-Өндөр, Шинэ-Идэр, Рашаант, Цэцэрлэг, Эрдэнэбулган сумдын улсын бүртгэгч нарт хуулийн этгээдийн улсын бүртгэл, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл хөтөлж эрх олгосон ба хуулийн этгээдийн бүртгэлийг 5 дугаар сараас эхлэн "Шинэ хоршоо" хөдөлгөөнтэй холбогдуулан цахимаар сургалт мэдээлэл, зөвлөгөө өгч Хоршооны бүртгэл хөтлүүлж, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийг 7 дугаар сараас эхлэн хөтлүүлж өдөр тутмын бүртгэлд нь хяналт тавьж, удирдлага арга зүйгээр ханган ажиллаж байгаа бөгөөд 2024 оны 10 дугаар сарын 28-ны өдрөөс 11 дүгээр сарын 08-ны өдрийг хүртэл хуваарь гарган 9 сумын улсын бүртгэгчийг хэлтэст биечлэн ирүүлж ажлын байрны сургалт өгч, дадлагажууллаа. Ингэснээр 12 суманд эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл болон хуулийн этгээдийн улсын бүртгэл хөтөлж байна.	100%
Зорилт 6. Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр хэрэгжүүлнэ.							
6.1.	Улсын бүртгэлийн ерөнхий газрын авлигын	-	Хөтөлбөрийн хүрээнд төлөвлөгөө боловсруулж батлуулж, хэрэгжүүлэн	0	1	Улсын бүртгэлийн ерөнхий газраас 2024.04.08-ны 2/4541 дугаар албан бичгээр ирүүлсэн Авлигын эсрэг үйл ажиллагааны 11 арга хэмжээ бүхий төлөвлөгөөний хэлтэст хамаарах 6 заалтын	

	эрсдэлийг бууруулах хамтарсан хөтөлбөр хэрэгжүүлэх. /2.6.2.3./		ажиллах			биелэлтийг тайлант хугацаанд 100% ханган ажилласан. Мөн хэлтсийн хэмжээнд авлигын эсрэг үйл ажиллагааг хангах 7 арга хэмжээг төлөвлөн биелэлтийг хангаж байна.	100%
6.2.	Авлигын эсрэг хууль тогтоомжийг иргэдэд сурталчлах, соён гэгээрүүлэх үйл ажиллагааны хүртээмжийг нэмэгдүүлэх	-	АТГ-аас бэлтгэсэн тв шторк, инфографик, видео график, нийтлэл, теле зохиомж, хөдөлгөөнт зураг, зурагт хуудас, цахим ном, гарын авлага зэргийг албан ёсны цахим хуудас болон нийгмийн сүлжээ, мэдээллийн самбарт байршуулж, олон нийтэд хүргэсэн тоо	0	16	Хэлтсийн “Хөвсгөл аймгийн улсын бүртгэлийн хэлтэс” фейж хуудсанд Авилгатай тэмцэх газраас соён гэгээрүүлэх чиглэлээр бэлтгэсэн - товш, - авлигад дасах ёсгүй, буруу аргаар олж авсан баялаг бүтэн амьдралыг ч сүйрүүлнэ, - муу найз үлгэрийн баатруудыг хэрхэн зурах бэ, - зоосон нүдлэсэн бүхнийг, танил тал, албан тушаалаараа далайлгасан үйлдэл болгосныг бүү тэвч, - шударга ёс хөгжил дэвшилд 110 авлигыг мэдээлэх утас - шидэт харандаа зэрэг подкаст бусад нэвтрүүлэг мэдээллийг байршуулан, түгээн ажиллалаа.	100%
			АТГ-аас санаачилсан аян, арга хэмжээг байгууллагын хэмжээнд зохион байгуулсан тоо	0	5	Хэлтсийн Авлигын эсрэг үйл ажиллагаа хариуцсан иргэний улсын бүртгэгч Б.Болормаа 2024 оны 02 дугаар сарын 29-ний өдөр хэлтсийн нийт 39 албан хаагчдад “Төрийн албаны тухай хууль, Нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлоос урьдчилан сэргийлэх хууль тогтоомжийг танилцуулах, зөрчил үйлдэгдэхээс урьдчилан сэргийлэх, зөрчил гаргахгүй” байх талаар сургалтыг зохион байгуулсан. Мөн Хэлтсийн ЭБАТ Б.Мөнгөнзул хэлтсийн 35 албан хаагчийн 2023 оны ХАСХОМ-ийг хуулийн хугацаанд цахимаар хүлээн авч баталгаажуулах, цаасан хэлбэрээр хүлээн авах, бүртгэх хадгалах ажлыг хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулж, тайлант хугацаанд шинээр томилогдсон 4 нийт 39 албан хаагчийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг болон хөрөнгө орлогын мэдүүлгийг гаргуулан Баталгааны маягтыг УБЕГ-т хүргүүлэн, нууцын баталгааг гаргуулан ажилласан. Хэлтсийн албан хаагчдын албан хэрэгцээнд ашигладаг компьютерийн ард “Авлигын эсрэг	100%

						нэгдье” сурталчилгааг байршуулан “Авлигын эсрэг нэгдье” саналын хайрцаг, брошурын тавиурыг үйлчилгээний зааланд байршуулан ажиллуулж байна.	
Зорилт 7. Чадахуйн зарчимд суурилсан хүний нөөцийг бүрдүүлж, албан хаагчдын нийгмийн баталгааг хангана.							
7.1.	Байгууллагын 2024 онд зохион байгуулах сургалтын төлөвлөгөөг хэрэгжүүлэх.	-	Сургалтын төлөвлөгөөний биелэлтийн хувь	100	100	Хэлтэст зохион байгуулах 2024 оны сургалтын төлөвлөгөөг 2024 оны 02 дугаар сарын 05-ны өдөр 14 арга хэмжээтэй боловсруулж хэлтсийн даргаар батлуулан төлөвлөгөөний дагуу холбогдох сургалтанд хамрагдаж байгаа бөгөөд тайлант хугацаанд Төрийн албаны зөвлөлөөс зохион байгуулсан 23, Улсын бүртгэлийн ерөнхий газраас болон аймгийн ЗДТГ, бусад байгууллагаас зохион байгуулсан нийт 63 удаагийн сургалтад хэлтсийн бүх албан хаагчид болон хэлтсийн дарга, холбогдох албан хаагчид бүрэн хамрагдсан байна. Мөн аймгийн Цагдаагийн газар, Гэр бүл хүүхэд залуучууд хөгжлийн газар, Хилийн цэргийн 0257 дугаар анги, Нийгмийн даатгалын газар, Прокурорын газар, Монгол банк, Төрийн банк, Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн төв, Онцгой байдлын газар, Тагнуулын ерөнхий газрын Хөвсгөл аймаг дахь хэлтэс, Титэм ЕБС, Авьяас ЕБС зэрэг байгууллагуудтай хамтран сургалтыг хэлтсийн албан хаагчдад танхимаар зохион байгуулсан. Мөн Эрдэнэбулган сумын улсын бүртгэгч Э.Сосорбурам Улсын бүртгэлийн ерөнхий газраас зохион байгуулсан Төрийн албанд анх томилогдсон албан хаагчийг чиглүүлэх богино хэмжээний сургалтад хамрагдан гэрчилгээ авах болзлыг хангасан.	100%
7.2.	Улсын бүртгэлийн байгууллагын хүний нөөц, сургалтын нэгдсэн системийг хэрэглээг нэмэгдүүлэх, холбогдох хуульд заасны дагуу	Төслөөр	Цахим сургалтын мэдээллийн баяжилтыг хийсэн хувь	80	100	Улсын бүртгэлийн байгууллагын хүний нөөц, сургалтын нэгдсэн системийн Бие даах хичээлийг албан хаагч нар тогтмол судалж, үнэлгээгээ ахиулан ажиллаж байна. Улсын бүртгэлийн ерөнхий газрын Хүний нөөц, сургалтын програмын бие даах 165 хичээлийг 35 албан хаагч судалж хэлтсийн биелэлт 89.2 хувьтай байна. Мөн хэлтэст шинээр томилогдсон 4 албан хаагчийг бие даах хичээлийн програмын эрхийг нээлгэн, хичээлийг судалж, шалгалтыг өгөхөөр	100%

	мэдээллийг цахим хуудаст байршуулах.					бэлтгэлийг ханган ажиллаж байна.	
7.3.	Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэгчийг хариуцлагын даатгалд даатгуулах	-	Даатгалд хамруулсан хувь	0	100	Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэгчийг хариуцлагын даатгалд даатгуулах ажлын хүрээнд Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэгч нар болон суманд эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл хөтөлж буй улсын бүртгэгч нарын судалгааг гарган Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн газарт хүргүүллээ.	100%
7.4.	Хэлтсийн албан хаагчдыг нэгдсэн дүрэм хувцсыг шинэчлэх	3 сая төгрөг	Хэлтсийн албан хаагчдын дүрэмт хувцас шинэчилсэн тоо	0	43	Хэлтсийн бүх албан хаагчдын хувцаслалтыг 100% жигдрүүлж, бомбер болон поло цамцыг захиалан хийлгэсэн.	100%
7.5.	Хэлтсийн албан хаагчдыг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулах	-	Урьдчилан сэргийлэх хамрагдсан албан хаагчдын тоо	30	47	“Тод онош” эмнэлзүйн лабораторын Зул бадам төслийн урилгаар Хөвсгөл аймагт ажиллах хугацаанд улсын бүртгэлийн хэлтсийн нийт 22 албан хаагч Хөвсгөл аймагт хийгдэдгүй хеликобактерийг амьсгалаар тоолох шинжилгээ болон хавдрын маркерын шинжилгээнд хамрагдаж зөвлөгөө мэдээллэл авав. Жаргалант, Рэнчинлхүмбэ, Тариалан, Цагаан-Уул, Улаан-Уул, Эрдэнэбулган зэрэг сумын улсын бүртгэгч нарыг тухайн сумын Засаг даргын тамгын газрын нэгдсэн зохион байгуулалттайгаар Улаанбаатар хот дахь Төрийн тусгай албан хаагчдын эмнэлэг, Орхон аймгийн Эрдэнэт Медипас эмнэлэгүүдэд хийгдэж буй эрүүл мэндийн бүтэн биеийн оношлогоо, шинжилгээнд хамрагдахад 5 хүртэлх хоногийн чалинтай чөлөө олгож мөн албан хаагчдийн хүсэлтийн дагуу эмчлүүлэх зайлшгүй шаардлагатай тусламж шаардлагатай бага насны хүүхэд албан хаагчдад эмнэлэгт хэвтэн эмчлүүлэх, болон богино хугацааны цалинтай чөлөөг чөлөөний хуудсаар олгож үүрэгт ажлыг нь бусад албан хаагчаар давхар гүйцэтгүүлэх байдлаар зохицуулалт хийж ажилласан байна.	100%
7.6.	Залуу боловсон хүчний нийгмийн баталгааг хангах зорилгоор гэр	-	Газар олгосон албан хаагчдын тоо	2	2	Хэлтсийн залуу боловсон хүчний нийгмийн баталгааг хангах зорилгоор Мөрөн, Эрдэнэбулган сумын Засаг даргын тамгын газар болон Иргэдийн төлөөлөгчдийн хуралд албан хаагчдад газар	100%

	бүлийн хэрэгцээний газар олгуулах ажлыг зохион байгуулах					олгуулах хүсэлтийг хэлтсийн удирдлагын зүгээс хүргүүлсэн.	
Зорилт 8. Орон нутагтай хамтын ажиллагааг өргөжүүлнэ.							
8.1	Орон нутгийн байгууллагын хамтын үйл ажиллагааг сайжруулах	-	Аймгийн ЗДТГ-н хэлтсүүд болон, бусад байгууллагатай хамтран ажилласан тоо	20	25	Хөвсгөл аймгийн Засаг даргын тамгын газар, Сумын ЗДТГ, Газрын харилцаа барилга хот байгууллагын газар, Цагдаагийн газар, Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн төв, Хилийн цэргийн 0257-р анги, Шүүх, Прокурор, ШШГГ, Онцгой байдлын газар, ЕБС-ууд Нийгмийн даатгалын газар, ГБЗХХГазар, Нотариат, Эрүүл мэндийн газар, Тагнуулын хэлтэс, Аймаг, сумын сонгуулийн хороо, Татварын хэлтэс, Банк ББСБ зэрэг төрийн үйлчилгээний болон захиргааны байгууллагуудтай хамтын ажиллагааг сайжруулан 68 арга хэмжээг хэрэгжүүлсэн байна.	100%
		-	Хууль зүйн яамны харъяа байгууллагатай хамтран ажилласан тоо	2	5	Хилийн цэргийн 0257-р дугаар ангитай харилцан ажиллах төлөвлөгөө батлан төлөвлөгөөний дагуу 3 арга хэмжээг амжилттай зохион байгуулсан. Мөн Цагдаагийн газраас 2 удаагийн сургалт, Гэр бүл батлах ёслолын ажиллагаа, аймгийн Прокурорын газраас 2 удаагийн сургалт, Онцгой байдлын газрын 1 удаагийн сургалт, Аймгийн ЗДТГ-н Хууль эрх зүйн хэлтэстэй хамтран 5 удаагийн хууль сурталчлах болон, улсын бүртгэлийн үйд ажиллагааг иргэдэд таниулах үйл ажиллагааг зохион байгуулж хамтын үйл ажиллагааг 100 хувь ханган ажиллаж байна.	100%
		-	Сумын Засаг даргын тамгын газартай хамтран ажилласан тоо	24	24	Хөвсгөл аймгийн 23 сум 1 тосгоын Засаг даргын тамгын газартай хамтран ажиллаж дараах ажлыг хийж гүйцэтгэсэн. Үүнд: 1. 9 сумын Засаг даргын тамгын газартай хамтран санхүүг шийдвэрлүүлэн 6 суманд цахим гадаад паспортын үйлчилгээг нэвтрүүлж, 3 суманд тоног төхөөрөмжийн худалдан авалтыг зохион байгуулж, "ГАРТ ОЙР-ГЭРТ ОЙР" гадаад паспортын үйл ажиллагаа хэрэгжсэн. 2. 11 сумын Засаг даргын тамгын газартай хамтран улсын бүртгэлийн байгууллагын	100%

						<p>“Нээлттэй хаалганы өдөр”-ийг зохион байгуулсан.</p> <p>3. 3 сумын улсын бүртгэгч сумын ЗДТГ-р төсвийг шийдвэрлүүлэн Гэрэгэ төлбөрийн системийг шийдвэрлэсэн.</p> <p>Мөн Сумын улсын бүртгэгч нар өдөр тутмын үйл ажиллагаанд сумын Засаг даргын тамгын газартай хамтран ажиллаж төрийн албан хаагчдыг үйл ажиллагааны ур чадвар, өөрийгөө хөгжүүлэх бүх төрлөөр манлайлан ажиллаж байна.</p>	
8.2	Аймгийн тойргийн нотариатчидтай хамтран сургалт зохион байгуулах	-	Сургалт зохион байгуулсан тоо	0	1	<p>Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хуулинд нэмэлт өөрчлөлт орсонтой холбогдуулан аймгийн тойргийн нотариатч нарт 2024 оны 02 дугаар сарын 20-ны өдөр Улсын бүртгэлийн ерөнхий газраас ирүүлсэн чиглэл, 2024 оны 04 дүгээр сарын 12-ны өдрийн 5/4803 чиглэлийг тухай бүр хүргүүлэн ажиллаж байна.</p>	100%
8.3	Хөвсгөл аймгийн Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн төвтэй хамтран ажиллах	800 мянган төгрөг	Хамтран ажилласан тоо	1	3	<p>Хөвсгөл аймгийн “Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн төв”-тэй хамтран ажиллаж, хөгжлийн бэрхшээлтэй хүний шаардлагыг тооцсон орон зай, орчны нөхцөл байдлын үнэлгээг хийлгэлээ. Уг үнэлгээний үр дүнд “Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн төв”-өөс 7 заалт бүхий зөвлөмжийг ирүүлсэн. Уг зөвлөмжийн дагуу тус хэлтсийн үйлчилгээний зааланд байрлах текийг намсгаж, тусгай хэрэгцээт болон өндөр настан иргэдэд үйлчилгээний стандартын дагуу үйлчилгээ үзүүлэх боломжийг бүрдүүллээ.</p> <p>Хөгжлийн бэрхшээлтэй иргэний хүний хөгжлийн төвтэй хамтран 4G зөөврийн тоног төхөөрөмж ашиглан улсын бүртгэлийн үйлчилгээг авах нөхцөл боломжийг бүрдүүлэн ажиллаж байгаа бөгөөд 2024 оны 03 дугаар сарын 14-ний өдөр “Хамтдаа нөлөөлье” аянд оролцож 15 иргэнд тоон гарын үсэг олгосон.</p> <p>Хөвсгөл аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн төвтэй хамтран Ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн 28 сурагчид ажил мэргэжлийн чиг баримжаа олгох зорилгоор</p>	100%

						<p>мэргэжил сонголтонд арга зүйн зөвлөгөө өгөх, байгууллагын үйл ажиллагаатай танилцах судалгаат аяллыг зохион байгуулсан.</p> <p>Улсын бүртгэлийн үйлчилгээг тэгш, хүртээмжтэйгээр хүргэх зорилгоор Баянзүрх, Галт, Тариалан, Арбулаг, Мөрөн, Эрдэнэбулган суманд амьдардаг өндөр настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, хүнд өвчтэй болон ерөнхий боловсролын сургуулийн сурагчдад зөөврийн 4G төхөөрөмж ашиглан тоон гарын үсэг олгох, биеийн давхцахгүй өгөгдлийн бүртгэл, иргэний шилжилт хөдөлгөөний бүртгэл, иргэний улсын бүртгэлийн лавлагаа зэрэг 27 иргэнд үйлчилгээг үзүүлэн ажиллалаа.</p> <p>Хэлтсийн "Хүний эрхийг хангах" болон "Хөгжлийн бэрхшээлтэй иргэний эрхийг хангах" 2024 оны төлөвлөгөөний дагуу хэлтсийн албан хаагчдад дохионы хэлний анхан шатны мэдлэг олгох сургалтыг Хөвсгөл аймгийн Хөгжлийн бэрхшээлтэй хүний төвийн мэргэжилтэн Х.Хишигбаяр зохион байгууллаа. Тус сургалтад сумдын болон хэлтсийн 25 албан хаагчид танхим болон онлайнгаар бүрэн хамрагдсан.</p>	
8.4	Аймгийн арилжааны банк болон банк бус санхүүгийн байгууллагуудтай хамтран ажиллах	-	Хамтран ажилласан тоо	2	3	<p>Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хуулинд нэмэлт өөрчлөлт орсонтой холбогдуулан Улсын бүртгэлийн ерөнхий газрын Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн газраас ирүүлсэн хамтран ажиллах тухай чиглэлийг аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа банк болон ББСБ-уудад албан бичгээр хүргүүлэн хамтран ажиллалаа. Мөн банк болон банк бус санхүүгийн байгууллагуудаас ЭУБ-06, ЭУБ-13 маягтуудыг үйлдэхдээ барьцаалуулагч болон өмчлөгчдийн мэдээллийг орхигдуулан дутуу оруулах ялангуяа насанд хүрээгүй өмчлөгчдийг орхиж бичих, улсын бүртгэлийн дугаар, гэрчилгээний дугаарыг буруу бичих, итгэмжлэлээр барьцаалж буй этгээдийн мэдээллийг бичихгүй орхих, өмчлөгчдийн гарын үсгийг дутуу зуруулдаг, хүсэлт гаргасан огноог бичихгүй орхих, барьцааны гэрээ дуусгавар болсон албан бичигт үүрэг дуусгавар болж буй гэрээний он сар өдөр, гэрээний дугаарыг буруу</p>	100%

						бичих зэрэг зөрчлүүд байнга гарч иргэдэд хүндрэл учруулж байгаа тал дээр анхаарч дээрх алдаа дутагдлыг гаргахгүй байх тал дээр хамтран ажиллах талаар албан бичиг хүргүүлэн ажилласан.	
8.5	Хэлтсийн байрны тог цахилгааны аюулгүй байдлыг хангаж, цахилгаан монтажийг шинэчлэх	50 сая төгрөг	Цахилгааны монтажийг шинэчилсэн хувь	0	50	Хэлтсийн байрны цахилгааны монтажийг солих асуудлаар Аймгийн засаг дарга П.Лхагважав, Л.Төмөрбаатар нарт болон ажлын хэсэгт хүсэлтээ уламжилсан. Шийдвэрлүүлэхээр тодорхой арга хэмжээнүүдийг хяналтандаа аван ажиллаж байна.	30%

Төлөвлөгөөг хянасан:

Төсвийн Төвлөрүүлэн захирагч

УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ
(албан тушаал)

..... /У.БОЛДХҮҮ/
(гарын үсэг)
2024.11.18
Тэмдэг

Төлөвлөгөө тайлагнасан:

Төсвийн Шууд захирагч

ХӨВСГӨЛ АЙМГИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН ДАРГА
(албан тушаал)

..... /Б.МӨНГӨНЗУЛ/
(гарын үсэг)
2024.11.18
Тэмдэг